




# ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

№3.

2001



**Сэтгүүлийн  
редакцийн  
ЗӨВЛӨЛ**

Дарга: **Б.Сувд**

Гишүүд:

- Д.Дагвадорж**
- П.Лувсандорж**
- Г.Миеэгомбо**
- Э.Сайнбилэг**
- Б.Сайнжаргал**

Техник редактор:

**Х.Энхмөнх**

**ХАЯГ:**

Улаанбаатар 46-А/121  
Монгол Улсын Их Сургууль  
Эдийн засгийн Сургууль

**УТАС: 350997**

**ФАКС: 976-11-350994**

**И-МЭЙЛ:**

**webmaster@ses.edu.mn**

**АГУУЛГА**

Өмнөх үг.....	2
Зохиогчид.....	3
1. “Transitional Economics: The Mongolian pattern and comparative analysis” P.Luvsandorj .....	4
2. “Poverty situation of Mongolia” B.Suvd, B.Altantsetseg .....	13
3. “Economies of Scale and the Home Market Effect” Ch.Khashchuluun .....	27
4. “Measuring inequality” S.Davaasuren .....	40
5. “Assessment of Mongolian trade policy” B.Otgontugs .....	51
6. “Хүнсний зарим барааны эрэлтийн шинжилгээ” Х.Цэвэлмаа .....	64
7. “Шинэ эдийн засаг” Б.Бат .....	70
8. “Зүүн Хойд Азийн интеграцид Монгол Улс оролцох нь” Д.Бямбаа, С.Отгонбаатар .....	74
9. “Банк, мөнгө-зээлийн тогтолцооны шинэчлэлийн асуудлууд” П.Оюунбилэг .....	89

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Эдийн Засгийн Боловсрол Холбоо хамтран гаргаж буй "ЭДИЙН ЗАСАГ: онол практик" сэтгүүлийн энэхүү дугаарыг МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим бэлтгэв.

Эдийн засгийн шинжлэх ухаанд "Шилжилтийн эдийн засаг" гэсэн шинэ салбар бий болж, шилжилтийн эдийн засгийн дэлхийн сургуулиуд (муужруулах эмчилгээ-цок трапей, аажим шилжилт-градуализм) төлөвших үйл явц өрнөж байна.

Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааныг шилжилтийн практикт нийцүүлэн хэрэглэж, баяжуулах замаар өөрийн гэсэн үндэсний сургуулийг төлөвшүүлэх нь монголын эдийн засагчдын эрхэм хүндтэй зорилго мөн. Манай орны эрдэмтэн, судлаач бүрийн хувь нэмэр эрдмийн энэ далайд дусал болж орох учиртай.

Сэтгүүлийн энэхүү дугаарт Монголын эдийн засгийн шилжилтийн онцлог, шилжилтийн эдийн засагтай орнуудын нийтлэгийг харьцуулсан судалгаагаар харуулав. Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны онолуудын үндсэн дээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн шинж байдалд үнэлгээ өгч түүнийг зах зээлд шилжүүлэхэд хэрэгтэй шинэчлэл, өөрчлөлтийн үндсэн чиглэлүүдийг тодорхойлов.

Сэтгүүлийн энэхүү дугаарт нийтлэгдэж байгаа Эдийн засгийн онол, практикийн бусад шинэ өгүүлэлүүд уншигчдад бүхний таалалд нийцнэ гэдэгт итгэж байна. Англи хэл дээр хэвлэгдэж байгаа өгүүлэлүүд нь Монголын эдийн засгийг сонирхогч гадаадын уншигчдын танин мэдэхүйд, хэлний мэдлэгээ нэмэгдүүлэхэд үндэсний уншигчдад тустай гэж үзэв.

Б.Сувд  
П. Лувсандорж

## ЗОХИОГЧИД

**Пунцагдашийн Лувсандорж.** Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн гишүүн (академич), Эдийн засгийн ухааны доктор, профессор. Судалгааны чиглэл: "Хөгжлийн эдийн засаг". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн гарын авлага" Улаанбаатар-Манчестер. 1999; "Монгол улс: шилжилтийн эдийн засгийн стратеги" EDAP JOINT POLICY STUDIES 4. KDI. 1998; "Шилжилтийн эдийн засаг: Монголын байдал ба туршлага" Northeast Asian Study Series 3. Tohoku University. 1999. THE MONGOLIAN ECONOMY: A Manual of Applied Economics for a Country in Transition. 2000 EE. Cheltenham, UK, Northampton, MA, USA.

**Батын Сувд.** Доктор (Ph), профессор. МУИС-ийн ЭЗС-ийн захирал. Судалгааны чиглэл: "Шилжилтийн үеийн нийгмийн салбарын шинэчлэл", "Монгол дахь ядуурлын асуудлууд". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн гарын авлага" номын хамтран зохиогч, редактор. Улаанбаатар-Манчестер. 1999, "Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл 2000" хамтран зохиогч, "Монгол улсын засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр", THE MONGOLIAN ECONOMY: A Manual of Applied Economics for a Country in Transition. 2000 EE. Cheltenham, UK, Northampton, MA, USA.

**Батчулууны Алтанцэцэг.** Эдийн засгийн ухааны магистр, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. Судалгааны чиглэл: "Эдийн засгийн өсөлт ба төрийн зохицуулалт". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд нь: "Экономикс" 2000, "Макро эдийн засаг" 2000, "Макро эдийн засаг, бодлого, дасгал, тест" 2000, 2001.

**Чулуундоржийн Хашчулуун.** Японы Иокохамагийн Их Сургуулийн докторант, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. "Эдийн засгийн өсөлт ба олон улсын худалдаа" сэдвээр докторын ажил хийж байна.

**Содномдаржаагийн Даваасүрэн.** Эдийн засгийн ухааны магистр, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. Судалгааны чиглэл: "Эдийн засгийн өсөлт, хөгжил, орлогын хуваарилалт". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд нь: "Макро эдийн засаг, бодлого, дасгал, тест" 2000, 2001.

**Банзрагчийн Отгонтөгс.** Эдийн засгийн ухааны магистр, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. Судалгааны чиглэл: "Олон улсын худалдааны бодлого". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Макро эдийн засаг" 2000, "ЭЗС-ын тэнхмээс зааж буй хичээлийн тодорхойлолт" 2000, "Макро эдийн засаг, бодлого, дасгал, тест" 2000, 2001.

**Хяргасын Цэвэлмаа.** МУИС-ийн докторант, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. Судалгааны чиглэл: "Хэрэглэгчийн зах зээлийн арга зүйн асуудал". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд нь: "Макро эдийн засаг, бодлого, дасгал, тест" 2000, 2001.

**Буянцогтын Бат.** Кюунгроокийн Их Сургуулийн докторант, МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. Судалгааны чиглэл: "Эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлт". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн гарын авлага" хамтран зохиогч. 1999, "Макро эдийн засаг, бодлого, дасгал, тест" 2000.

**Дүлбаагийн Бямбаа.** Доктор (Ph), профессор. МУИС-ийн ЭЗС-ийн Эдийн засгийн онолын тэнхимд багш. Судалгааны чиглэл: "Монголын эдийн засгийн сэтгэлгээний түүх, макро эдийн засгийн бодлого". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Макро эдийн засаг" 1998, "Англи-Монгол, Монгол-Англи эдийн засгийн толь" 1998, "Нийгмийн тухай мэдлэг" 2000, "Монголын эдийн засгийн түүх" 2001.

**Сангидоржийн Отгонбаатар.** ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн докторант. Судалгааны чиглэл: "Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграци"

**Пагжийн Оюунбилэг.** МУИС-ийн докторант, МУИС-ийн ЭЗС-ийн Математик-Компьютерийн тэнхимд ахлах багш. Судалгааны чиглэл: "Банкны зээл, зээлийн үр ашиг, системийн шинжилгээ загвар". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Windows орчны дрограммчлалын Delphi систем" сурах бичиг 2000.